



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

“Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээнд оролцох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай” 333 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09, 2022 оны 65 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1206, А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээнд 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг ажиллуулж иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээнд зориулан дотоодын аялагч нарын аяллын боловсролыг нэмэгдүүлэх дотоодын аяллын мэдээ мэдээлэл бүхий А5 хэмжээтэй гарын авлагын эх бэлтгэл болон хэвлэл гүйцэтгэхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 5,000,000 (таван сая) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.


3. Зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (В.Батчимэг)-т даалгасугай.

ДАРГА *D. Balm* Д.БАТЦУХ



1150500217

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 10 сарын 06 өдрийн
А/СС дугаар тушаалын хавсралт



“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭВЛЭЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2022 оны 10 дугаар сарын 06

Улаанбаатар хот

№	Зардлын зүйл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бидний мэдэх найрсаг Улаанбаатар /Гарын авлага А5/ Эх бэлтгэл	1	600.000	600.000
2	Бидний мэдэх найрсаг Улаанбаатар /Гарын авлага А5/ Хэвлэлт	2000	2200	4.400.000
Нийт				5.000.000

--- оОо ---